

ПАРКИЙН НЭГЖЭЭС ПАРКИЙН УДИРДЛАГАД ТӨЛӨХ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ, ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар үйлдвэрлэл, технологийн парк (цаашид “парк” гэх)-ийн удирдлагаас паркийн нэгжид үйлчилгээ үзүүлсний төлөө хураамж ногдуулах, хураамжийн хэмжээг тодорхойлох, хураамжаас хөнгөлөх, төлөх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Парк нь үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологийн цогцолбор байна.

1.3.Энэ журмаар паркийн удирдлагаас паркийн нэгжид харилцан тохиролцсоны дагуу, гэрээний үндсэн дээр бараа, ажил, үйлчилгээ борлуулах тохиолдолд төлөх төлбөрийн хэмжээг тогтоохгүй.

Хоёр.Хураамж ногдуулах үндэслэл

2.1.Парк нь бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлсэн байна.

2.2.Паркийн удирдлага нь паркийн нэгжтэй Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13.3.2-т заасан гэрээг байгуулж, дараах шаардлагыг хангасны үндсэн дээр хураамж ногдуулна:

2.2.1.паркийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах паркийн дэд бүтэц, барилга байгууламж, туслах дэд бүтцийг барьж байгуулсан байх;

2.2.2.паркийн нутаг дэвсгэрээс газар ашиглах эрхийг олгосон байх;

2.2.3.паркийн нэгжид захиргааны үйлчилгээ үзүүлэх;

2.2.4.байгаль орчныг хамгаалах;

2.2.5.бизнес хөгжил, инновацийг дэмжих нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.2.6.паркийн нэгжийн өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх;

2.2.7.паркийн нэгжийн үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамаарах;

2.2.8.хуульд заасан бусад.

2.3.Паркийн удирдлага нь гэрээний үндсэн дээр энэ журмын 2.2.1-т заасан дэд бүтцийн тодорхой хэсгийг паркийн нэгжээр гүйцэтгүүлж болно.

Гурав.Хураамжийн төрөл, түүний хэмжээг тодорхойлох

3.1. Паркийн удирдлага нь энэ журмын 2.2-т заасан шаардлагын хүрээнд дараах төрлийн хураамжийг ногдуулна:

3.1.1. паркийн дэд бүтэц, барилга байгууламж, туслах дэд бүтцийн ашиглалт, засвар үйлчилгээний хураамж;

3.1.2. газар ашиглуулах үйлчилгээний хураамж;

3.1.3. дараах захиргааны үйлчилгээнээс хураамж авна:

3.1.3.1. мэдээллийн сангийн үйлчилгээ;

3.1.3.2. паркийн нэгжийн шуудан харилцаа, холбоог хэрэгжүүлэх;

3.1.3.3. орчуулгын үйлчилгээ;

3.1.3.4. хөрөнгө оруулалт хүсэх хүсэлтийг бүртгэх үйлчилгээ;

3.1.3.5. эд хөрөнгийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын үйлчилгээ;

3.1.2.6. валют арилжаа;

3.1.3.7. ус, цахилгаан, дулаан, газ, шатахуун тосоор хангах үйлчилгээ;

3.1.3.8. хаягдал ус цэвэршүүлэх, дахин ашиглах, ариутгах татуургын

үйлчилгээ

3.1.3.9. үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, нэгтгэх үйлчилгээ;

3.1.3.10. паркийн оршин суугчдад зориулсан соёл амралтын үйлчилгээ.

3.1.4. нэгжийн эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний ус цэвэрлэх, тоосонцор, дуу чимээ, агаарын бохирдол, аюултай хог хаягдлын барилга байгууламжийн стандартыг мөрдүүлэх;

3.1.5. бизнес хөгжил, инновацийг дэмжих үйлчилгээний хураамж:

3.1.5.1. паркт шинэ нэгж, хөрөнгө оруулагч, бизнесийг татах маркетинг, зар сурталчилгаа хийх;

3.1.5.2. судалгаа хөгжил, мэдлэг хуваалцах талбараар хангах;

3.1.5.3. чадварлаг, мэргэшсэн боловсон хүчин татах;

3.1.5.4. нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;

3.1.5.5. бүтээгдэхүүний агуулах, тээвэрлэлт, аюулгүй байдлыг хангах;

3.1.5.6. экспорт, гаальтай холбоотой үйлчилгээ;

3.1.5.7. бизнесийн зөвлөх үйлчилгээ;

3.1.5.8. инновацийг дэмжих бизнес инкубатор төвийн үйл ажиллагаа;

3.1.5.9. хурал, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, бүтээгдэхүүн танилцуулах үйлчилгээ.

3.1.6. Паркийн удирдлага нь осол гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд энэ журмын 3.1.3.5-т заасан үйлчилгээг паркийн нэгжтэй хамтран хэрэгжүүлж болно.

Дөрөв.Хураамжийн хэмжээ ба хөнгөлөлт

4.1.Энэ журмын 3.1-т заасан хураамжийг дараах хэмжээгээр тооцож, ногдуулна:

4.1.1.энэ журмын 3.1.1, 3.1.3, 3.1.4, 3.1.5-т заасан үйлчилгээний хураамжийг паркийн удирдлага нь паркийн нэгжтэй харилцан тохиролцож, гэрээний дагуу тодорхойлно.

4.1.2.энэ журмын 3.1.2-т заасан үйлчилгээний хувьд паркийн нэгжид ашиглуулж буй газрын хэмжээнд ногдох газрын төлбөрийн 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү.

4.2.Газрын төлбөрийн тухай хуулийн 8.1.9-т заасны дагуу паркийн удирдлага газрын төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаанд энэ журмын 4.1.2-т заасан хураамжийн гуравны хоёрыг хөнгөлнө.

Тав.Хураамжийг төлөх, хяналт тавих

5.1.Энэ журмын 4.1.2-т заасан хураамжийг жилд нэг удаа тухайн жилийн эхний улиралд багтаан паркийн удирдлагын дансанд тушаана.

5.2.Паркийн нэгж нь хураамжийг тогтоосон хугацаанд төлөхгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.

5.3.Паркийн нэгж нь хураамжийг төлөхөд санхүүгийн хүндрэлтэй бол энэ талаар паркийн удирдлагад мэдэгдэж, хураамжийг төлөх хугацааг хойшлуулах хүсэлт гаргана.

5.4.Паркийн нэгж нь хураамжийг төлөхгүй 3 сар болон түүнээс дээш хугацаа өнгөрсөн бол паркийн удирдлагаас паркийн үйлчилгээг үзүүлэхгүй байх эрхтэй.

5.5.Паркийн нэгж нь энэ журмыг 5.4-т заасан зөрчлийг давтан гаргасан, эсхүл нэг удаад 6 сар ба түүнээс дээш хугацаагаар хураамжийг төлөхгүй бол паркийн удирдлага нь паркийн нэгжтэй байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.

----oO----